

**СОНГОГЧИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ, БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН
ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3

*I. Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргыг
сонгох тухай асуудал* 3

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны
10 дугаар сарын 25-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны дарга Г.Ганболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 3 гишүүнээс 2 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 40 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Тасалсан: Ц.Мөнх-Оргил.

Нэг.Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Золжаргал, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох нар байлцав.

Дэд хорооны дарга Г.Ганболд Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийг Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргад нэр дэвшүүлж байгаа талаар танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Ганболд: Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 0
Бүгд: 2
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Дэд хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 минут үргэлжилж, 3 гишүүнээс 2 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 43 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
СОНГОГЧИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ,
БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН
ДЭД ХОРООНЫ ДАРГА

Г.ГАНБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
13 цаг 40 минут.

СОНГОГЧИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ, БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Ганболд: Дэд хорооны гишүүдийн өдрийн амгаланг айлтгаж байна. Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Г.Ганболд нар хүрэлцэн ирж, хуралдааны ирц хүрсэн тул хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг танилцуулъя. Өнөөдрийн хурлаар Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад санал хэлэх, асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Тэгээд хэлэлцэх асуудлынхаа төлөвлөгөөг баталъя.

Хэлэлцэх асуудлын дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр орсон нэмэлтийн дагуу 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсэгт Дэд хорооны даргыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар гишүүдийн олонхын саналаар сонгох бөгөөд Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргыг цөөнхийн бүлгийн гишүүдээс хэрэв цөөнхийн бүлэг байгуулах гишүүдийн тоо хүрэхээргүй бол цөөнхийн гишүүдээс сонгоно гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Жамбын Батсуурийг тус хорооны бүрэлдэхүүнд оруулж, даргаар сонгох хүсэлт

ирүүлсний дагуу Батсуурь гишүүнийг Дэд хорооны даргад нэр дэвшүүлж байгаа юм.

Нэр дэвшигчээс асуух асуулттай болон үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна, асуулт, үг тасалъя. Ингээд Байнгын хороонд оруулах би тогтоолын төслийг танилцуулъя. Эхлээд ямар ч гэсэн Батсуурийг Дэд хорооны даргаар дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Тэгнэ шүү дээ. Хуралдаанд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар Ж.Батсуурийг Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргаар сонгоё гэсэн саналыг 100 хувийн саналаар дэмжлээ.

Ингээд Байнгын хороонд бид нар тогтоолын төсөл оруулах ёстой. Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулъя. Дэд хорооны даргыг сонгох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8, 28.9 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын тогтоох нь.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурийг Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргаар сонгосугай гэсэн энэ тогтоолын төслийг Байнгын хороонд Дэд хорооны гишүүн Ганболд миний бие танилцуулна.

13.43 цаг

Өнөөдрийн ингээд Дэд хорооны хурлаар хэлэлцэх асуудал өндөрлөж байна.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА**